



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАГАНУУР ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/01/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: Э.Бат-Эрдэнэ
Утас: 263533 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

| | |
|--|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ..... | 4 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН..... | 6 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 6 |
| 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан | 7 |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан | 9 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 10 |
| 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл | 10 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 12 |
| 3.1 Компани, түүний үйл ажиллагаа | 12 |
| 3.2 Компанийн гадаад, дотоод орчин..... | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 13 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт | 13 |
| 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл..... | 14 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 16 |
| 4.1 Ерөнхий зүйл | 16 |
| 4.2 Материаллаг байдал..... | 16 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 16 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 16 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 18 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 19 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 20 |
| 5.1 Төлбөрийн акт | 21 |
| 5.2 Албан шаардлага | 21 |
| 5.3 Зөвлөмж..... | 23 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 24 |
| 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл..... | 24 |
| 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл..... | 25 |
| 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 27 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НББОУС | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТЗБАХ | Техник зохион байгуулалтын арга хэмжээ |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ЭХЗХ | Эрчим хүчний зохицуулах хороо |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Тасгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Мингалтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15180
Утас: 25 04 37, Факс: (976-51) 25 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

БАГАНУУР ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

2025.03.21 № 07/1132
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 3.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд хөрс хуулалт, нүүрс тээврийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай машин, тоног төхөөрөмжийг шинээр худалдан авч, сүүлийн жилүүдэд хийгдээгүй байсан технологийн авто машинуудын хөдөлгүүр болон их засваруудыг хийж, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд нийт 33,643.4 сая төгрөг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд нийт 244,296.3 сая төгрөг орлого олж, 251,657.0 сая төгрөг зардал гарган 7,360.7 сая төгрөг алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 241,590.0 сая төгрөг орлого олж, 239,938.4 сая төгрөг зардал гарган 1,651.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 36,566.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 33,643.4 сая төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 588 дугаар тогтоолоор 1 тонн нүүрсний үнийг 43,310.00 төгрөгөөр баталсан байсныг 2024 оны 694 дүгээр тогтоолоор 54,091.00 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---------------|---|---------------------------|---------------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 2,417,234,743.19 | 6,366,982,530.30 |
| 1.1.2 | Дансны авлага | 4,547,818,310.13 | 4,690,594,574.18 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | 27,915,379.57 | 2,640,878.45 |
| 1.1.4 | Бусад авлага | 3,646,675,927.80 | 1,951,272,638.91 |
| 1.1.6 | Бараа материал | 49,354,185,876.94 | 49,105,511,778.28 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | - | 2,311,999,968.54 |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | 59,993,830,237.43 | 64,429,002,368.64 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 169,952,205,306.91 | 168,599,587,652.46 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 4,600,596,254.79 | 4,616,514,877.36 |
| 1.2.3 | Уул уурхайн хөрөнгө /Хөрс хуулалт/ | 25,563,066,622.70 | 25,169,955,715.80 |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 999,767,331.34 | 615,704,292.34 |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 764,393,387.00 | 764,393,387.00 |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | 3,609,958,909.70 | 1,328,603,776.54 |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 205,489,987,812.44 | 201,094,759,701.50 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 265,483,818,049.87 | 265,523,762,070.14 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | Өр төлбөр | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 60,720,143,664.51 | 62,906,234,850.58 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 2,616,642,414.86 | 2,589,819,924.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 53,284,067,637.36 | 78,622,743,330.34 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 8,287,925,455.68 | - |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | 3,766,628,727.10 | 13,356,223,186.00 |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | 12,968,712.50 | - |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 1,640,742,814.39 | 1,550,967,618.04 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 50,788,049.31 | 97,299,475.59 |
| | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 130,379,907,475.71 | 157,123,288,384.55 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 102,185,389,999.85 | 91,243,334,940.28 |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | 1,167,266,443.09 | 1,167,266,443.09 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 9,187,960,486.21 | 9,136,501,019.22 |
| | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 112,540,616,929.15 | 101,547,102,402.59 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 242,920,524,404.86 | 258,670,390,787.14 |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Өмч-төрийн | 1,573,077,000.00 | 1,573,077,000.00 |
| 2.3.2 | - хувийн | 524,359,000.00 | 524,359,000.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 60,685,388,076.98 | 63,295,572,091.86 |
| 2.3.8 | Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг | - | 3,702,426,000.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (40,219,530,431.97) | (62,242,062,808.86) |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 22,563,293,645.01 | 6,853,371,283.00 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 265,483,818,049.87 | 265,523,762,070.14 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|---|---------------------------|--------------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 210,096,473,086.23 | 237,581,225,691.92 |
| 2 | Борлуулалтын өртөг | 204,142,122,501.47 | 217,369,427,229.47 |
| 3 | Нийт ашиг(алдагдал) | 5,954,350,584.76 | 20,211,798,462.45 |
| 4 | Түрээсийн орлого | 34,070,947.73 | 45,081,745.46 |
| 5 | Хүүгийн орлого | 13,894,581.72 | 23,265,228.67 |
| 6 | Ногдол ашгийн орлого | 12,863,696.52 | 377,061,963.56 |
| 8 | Бусад орлого | 386,737,611.97 | 2,744,391,353.17 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 647,053,456.31 | 694,205,527.44 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 13,265,655,474.83 | 15,975,522,292.00 |
| 11 | Санхүүгийн зардал | 2,685,116,635.38 | 4,008,421,198.11 |
| 12 | Бусад зардал | 885,872,898.97 | 1,335,828,392.78 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 1,566,308,195.77 | 819,020,429.18 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (9,515,472,847.02) | 2,206,641,772.16 |
| 19 | Орлогын татварын зардал | 1,389,458.17 | 554,984,490.04 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | (9,516,862,305.19) | 1,651,657,282.12 |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (9,516,862,305.19) | 1,651,657,282.12 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| 24 | Орлогын нийт дүн | (9,516,862,305.19) | 1,651,657,282.12 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | - |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|--|-------------------------|---|------------------------------|----------------------------|--------------------------|
| 2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 2,097,436,000.00 | 60,685,388,076.98 | - | (28,546,450,831.52) | 34,236,373,245.46 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - | - |
| Залруулсан үлдэгдэл | 2,097,436,000.00 | 60,685,388,076.98 | - | (28,546,450,831.52) | 34,236,373,245.46 |
| Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал) | - | - | - | (9,516,862,305.19) | (9,516,862,305.19) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | (2,156,217,295.26) | (2,156,217,295.26) |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - |
| 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 2,097,436,000.00 | 60,685,388,076.98 | - | (40,219,530,431.97) | 22,563,293,645.01 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - | - |
| Залруулсан үлдэгдэл | 2,097,436,000.00 | 60,685,388,076.98 | - | (40,219,530,431.97) | 22,563,293,645.01 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | 2,610,184,014.88 | 3,702,426,000.00 | (23,674,189,659.01) | (17,361,579,644.13) |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | 1,651,657,282.12 | 1,651,657,282.12 |
| 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 2,097,436,000.00 | 63,295,572,091.86 | 3,702,426,000.00 | (62,242,062,808.86) | 6,853,371,283.00 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаар болсон тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2023 оны 12 сарын 31 | 2024 оны 12 сарын 31 |
|---------------|---|----------------------------|----------------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 211,205,772,188.83 | 236,751,140,252.90 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 210,909,990,145.16 | 236,221,865,182.01 |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | 269,520,748.42 | 384,739,247.55 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 26,261,295.25 | 144,535,823.34 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 201,263,308,232.25 | 215,058,086,616.04 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 41,605,342,476.92 | 48,219,477,862.73 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 17,278,689,407.40 | 23,876,227,349.56 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 77,268,930,989.11 | 77,030,502,580.61 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | - | 104,500.00 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 50,828,908,506.36 | 49,102,924,244.98 |
| 1.2.6 | Хүүгийн төлбөрт төлсөн | 1,044,881,385.10 | 429,205,919.32 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 10,856,724,554.40 | 10,059,756,471.33 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 2,379,830,912.96 | 6,339,887,687.51 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 9,942,463,956.58 | 21,693,053,636.86 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 13,801,304.98 | 23,257,056.10 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 13,801,304.98 | 23,257,056.10 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 25,517,179,533.48 | 20,602,209,836.06 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 25,406,785,735.48 | 20,337,117,651.70 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 110,393,798.00 | 265,092,184.36 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (25,503,378,228.50) | (20,578,952,779.96) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 55,004,840,525.00 | 40,071,275,287.00 |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 55,004,840,525.00 | 40,071,275,287.00 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 41,008,796,217.77 | 37,235,569,846.79 |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 41,008,796,217.77 | 37,235,569,846.79 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 13,996,044,307.23 | 2,835,646,930.21 |
| 4 | Валютын ханшийн зөрүү | (218,824.17) | (58,510.00) |
| 5 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (1,565,088,788.86) | 3,949,747,787.11 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 3,982,323,532.05 | 2,417,234,743.19 |
| 7 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,417,234,743.19 | 6,366,982,530.30 |

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| д/д | Үзүүлэлт | хэмжих нэгж | 2023 оны гүйцэтгэл | 2024 оны | | | |
|---|---|-------------|--------------------|---------------|---------------|---------------|-------|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | хувь |
| А Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт биетээр | | | | | | | |
| 1 | Нүүрс гаргалт | мян тн | 4,648.4 | 4,844.0 | 4,957.4 | 113.4 | 102.3 |
| 2 | Нүүрс борлуулалт | мян тн | 4,628.1 | 4,844.0 | 4,916.1 | 72.0 | 101.5 |
| 3 | Хөрс хуулалт | мян м3 | 17,866.7 | 20,890.0 | 19,183.3 | (1,706.7) | 91.8 |
| 4 | Нийт уулын цул | мян м3 | 29,098.1 | 31,412.3 | 30,633.0 | (779.3) | 97.5 |
| Б Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үнийн дүнгээ | | | | | | | |
| 5 | Нийт орлого | мян төг | 212,597,765.7 | 244,296,325.5 | 241,590,046.4 | (2,706,279.1) | 98.9 |
| 6 | Үүнээс: Цэвэр орлого | мян төг | 210,096,473.1 | 241,070,055.2 | 237,581,225.7 | (3,488,829.5) | 98.6 |
| В Нийт зардал | | | | | | | |
| 7 | Үүнээс: Удирдлагын зардал | мян төг | 13,265,655.5 | 13,553,248.5 | 15,975,522.3 | (2,422,273.8) | 117.9 |
| 8 | Нийгмийн зардал | мян төг | 3,770,400.4 | 4,138,732.0 | 4,180,625.1 | 41,893.1 | 101.0 |
| Г ТТӨА | | | | | | | |
| 9 | Орлогын албан татварын зардал | мян төг | - | - | 554,984.5 | 554,984.5 | - |
| 10 | Цэвэр ашиг | мян төг | (9,541,882.3) | (7,360,661.9) | 1,651,657.3 | 9,012,319.2 | 222.4 |
| 11 | Төсөвт төлөх нийт төлбөр | мян төг | 47,099,246.9 | 55,187,493.5 | 58,019,460.5 | 2,831,967.0 | 105.1 |
| 12 | Үүнээс : Орлогын татвар | мян төг | - | - | - | - | - |
| 13 | Ажиллагсдын тоо | хүн | 1,117.0 | 1,122.0 | 1,118.0 | (4.0) | 99.6 |
| 14 | Цалингийн сан | мян төг | 52,855,302.2 | 63,016,384.7 | 61,419,781.9 | (1,596,602.8) | 97.5 |
| 15 | Авлага | мян төг | 8,222,409.6 | 8,222,409.6 | 6,644,508.1 | (1,577,901.5) | 80.8 |
| 16 | Өр төлбөр | мян төг | 242,920,524.4 | 250,065,928.7 | 258,670,390.8 | 8,604,462.1 | 103.4 |
| 17 | Үүнээс : Богино хугацаат өглөг | мян төг | 130,379,907.5 | 153,174,947.2 | 157,123,288.4 | 3,948,341.2 | 102.8 |
| 18 | Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал | төгрөг | 1.0 | 1.0 | 1.0 | - | 104.0 |
| 19 | Хөрөнгө оруулалт | мян төг | 41,174,247.4 | 36,566,505.2 | 33,643,387.7 | (2,923,117.5) | 92.0 |
| 20 | 1 тонн нүүрсний өртөг | мян төг | 47,783.0 | 51,952.3 | 48,458.4 | (3,493.9) | 93.3 |
| 21 | Хөрс хуулалтын коэффициент | м3/тн | 3.8 | 4.3 | 3.9 | (0.4) | 89.7 |
| 22 | Аваар сватал | тоо | - | - | - | - | - |
| 23 | Ус шүүрүүлэлт | мян.м3 | 5,377.2 | 5,500.0 | 6,003.0 | 503.0 | 109.1 |
| 24 | Байгаль орчин шинэчлэлт, инновацийн асуудлыг шийдсэн байдал | мян төг | 436,939.7 | 930,926.0 | 779,629.1 | (151,296.9) | 83.7 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Багануур ХК нь эрхэм зорилгоо "Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацад суурилсан үндэсний тэргүүлэгч компани болоход оршино" гэж тодорхойлжээ.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг "Байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөгүй, дэвшилтэт техник, технологийг ашиглан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулж, хэрэглэгчдийг стандарт чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангаж, хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн үр ашигтай бизнес эрхлэхийг үндсэн зорилгоо болгон нүүрс олборлолт, баяжуулалт, боловсруулалт, борлуулалтын чиглэлийн үйл ажиллагаа явуулна" гэж тусгасан байна. Үүнд:

- Нүүрсний олборлолт, баяжуулалт, боловсруулалт, борлуулалт;
- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа;
- Багануур сувилал ХХК-ийн үйлчилгээ;
- Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

Тус компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нийт хувьцааны 75 хувийг төрийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа Эрдэнэс Монгол ХХК, 21.06 хувийг Монголиан коал корпорейшн ХХК, 3.94 хувийг аж ахуйн нэгж, хувь хүмүүс эзэмшиж байна. Мөн тус компани нь Багануур сувилал ХХК-ийн хувьцааг 100 хувь, Мон цахим ХХК-ийн хувьцааны 46 хувийг тус тус эзэмшдэг.

Уул уурхайн, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/16 дугаар тушаалаар баталсан "Уурхай, уулын баяжуулах, үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам"-ын 2.1.2 дахь заалтыг үндэслэн Багануур ХК-ийн нүүрсний ил уурхайг ашиглалтад авах Улсын комиссын шийдвэр 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр гарсан. Энэ шийдвэртэй холбоотой 2022 оны эхний улиралд уурхайн дунд хугацааны ТЭЗҮ-г боловсруулж батлуулснаар уурхайн хүчин чадал 4-10 сая тоннд хүрч борлуулалт нэмэгдэх боломжтой болсон байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Тус компани нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн 1977 оны 368 дугаар тогтоолоор 1978 онд үүсэн байгуулагдсан ба Төвийн эрчим хүчний системийн харьяа Дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зорилгоор ажиллаж эхэлсэн. 1995 онд хувьцаат компани, 2012 онд "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компани болон статус нь өөрчлөгдсөн ба жилд 4 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай. Компани эрчим хүч үйлдвэрлэгч байгууллагуудыг нүүрсээр хангахаас гадна хот орчмын айл өрх, аж ахуйн нэгж, ойр орчмын сумуудын уурын зууханд нийлүүлдэг. Компанийн удирдах дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд түүнийг төлөөлөн удирдан ажиллах байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

Тус компани нь Компанийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль;
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль;
- Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрэм;
- Ажилтны мэдээллийг авах, боловсруулах, ашиглах, хадгалах журам;

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод хяналт шалгалтын алба нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1 болон Дотоод хяналт шалгалтын албаны ажиллах журмыг баримтлан, албаны дарга, санхүүгийн хяналтын 2 ажилтан, хуулийн хяналтын ажилтан, техникийн хяналтын ажилтан, технологийн хяналтын ажилтан зэрэг нийт 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2024 онд "Хяналт шалгалтыг чанартай гүйцэтгэж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж ажиллах" зорилт дэвшүүлэн 38 хяналт хийхээр төлөвлөн 43 ажил хийгдэж, 72 зөвлөмж өгсөний 60 зөвлөмж хэрэгжиж хэрэгжилт 83.5 хувьтай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компани нь Эрдэнэс Монгол ХХК-ийн группийн хэмжээнд 2018 онд баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна.

Компанийн бизнесийн үйл ажиллагаа болон бүртгэлийн нийтлэг зарчмыг хангахгүй, шинэчлэгдэн мөрдөж байгаа НББОУС болон СТОУС-ыг хэрэглээг тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| ҮЗҮҮЛЭЛТ | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ |
|--|----------------------|----------------------|--------------------|
| | | | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө | 2,417,243.7 | 6,366,982.5 | 3,949,747.8 |
| Авлага | 8,222,409.6 | 6,644,508.1 | (1,577,901.5) |
| Бараа материал | 49,354,185.9 | 49,105,511.8 | (248,674.1) |
| Урьдчилж төлсөн зардал/ тооцоо | - | 2,311,999.9 | 2,311,999.9 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 3,609,958.9 | 1,328,603.8 | (2,281,355.1) |
| Үндсэн хөрөнгө | 201,880,028.9 | 199,766,156.0 | (2,113,872.9) |
| Нийт хөрөнгийн дүн | 265,483,818.0 | 265,523,762.1 | 39,944.1 |
| Өр төлбөр | 242,920,524.4 | 258,670,390.8 | 15,749,866.4 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 22,563,293.6 | 6,853,371.3 | (15,709,922.3) |
| Өр төлбөр ба эздийн өмчийн дүн | 265,483,818.0 | 265,523,762.1 | 39,944.1 |

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтүүдээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал/тооцоо, эргэлтийн бус хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч дансдуудад материаллаг дүнгээр дараах өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 6,367.0 сая төгрөг болж, 3,949.8 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь арилжааны банкны гүйлгээ хаагдсаны дараа 2,838.2 сая төгрөгийн нүүрсний төлбөр орж ирсэнтэй холбоотой.
- Нийт авлагын үлдэгдэл 6,644.5 сая төгрөг болж, 1,577.9 сая төгрөгөөр буурсан нь татварын авлага 27.9 сая төгрөгөөр, бусад авлага 1,695.4 сая төгрөгөөр буурсантай холбоотой
- Бараа материал дансны үлдэгдэл 49,105.5 сая төгрөг болж, 248.7 сая төгрөгөөр буурсан нь нүүрсний үлдэгдэл 1,614.8 сая төгрөгөөр өсөж, бусад сэлбэг материал 1,863.5 сая төгрөгөөр буурсантай холбоотой
- Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 2,312.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн хөрөнгө капиталжуулалт 2,184.4 сая төгрөгөөр хэрэгжээгүй, НӨАТ-ын авлага 127.6 сая төгрөгөөр тус тус өссөн
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 199,766.2 сая төгрөг болж 2,113.9 сая төгрөгөөр буурсан нь ТУЗ-ийн 2024 оны 6 дугаар тогтоолоор 8 газрыг 3,702.4 сая төгрөгөөр үнэлж бүртгэлд тусгасан, ТУЗ-ийн 2024 оны 5 дугаар тогтоолоор 2,628.9 сая төгрөгийн хөрөнгө дахин үнэлсэн, өөрийн хөрөнгөөр 30,011.8 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэж, тайлант онд 37,692.2 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой
- Өр төлбөр дансны үлдэгдэл 258,670.4 сая төгрөг болж, 15,749.9 сая төгрөгөөр өссөн нь татварын өглөг 23,338.7 сая төгрөгөөр, богино хугацаат зээл 9,589.6 сая төгрөгөөр тус тус өсөж, НДШ-ийн өглөг 8,287.9 сая төгрөгөөр буурч, Сангийн яамны JВIC-н зээл оны эхэнд 13,077.6 сая төгрөг байсныг тайлант онд төлж дуусгасан зэрэг нь нөлөөлсөн
- Засгийн газрын хувь оролцоо буюу эздийн өмч оны эхнээс 15,709.9 сая төгрөгөөр буурч 6,853.4 сая төгрөг болсон. Тайланд онд татварын ерөнхий газрын хяналт шалгалтын актаар 11,824.8 сая төгрөгийн торгууль алданги, Улсын дээд шүүхийн тогтоолоор Зуун найман ойл ХХК-д төлөх төлбөрийг хугацаанд нь төлөөгүй алданги 4,973.6 сая төгрөгийг өмнөх үеийн хуримтлагдсан ашиг дансанд бүртгэсэн нь эздийн өмч буурах шалтгаан болсон

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Багануур ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 7 дугаар тогтоолоор 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталжээ. Тайлант онд 242,839.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 250,691.2 сая төгрөгийн зардал гарган 7,851.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 36,566.5 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Багануур ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 28 дугаар тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон нийт орлогыг 244,296.3 сая төгрөг, нийт зарлагыг 251,657.0 сая төгрөг, 7,360.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 36,566.5 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Багануур ХК нь тайлант онд 4,844.0 мян.тн нүүрс борлуулах төлөвлөгөөтэй ажиллан, 4,957.4 мян.тн нүүрс олборлож 113.4 хувийн гүйцэтгэлтэй, 20,890.0 мян.м3 хөрс хуулах төлөвлөгөөг 91.8 хувийн гүйцэтгэлтэй буюу 19,183.3 мян.м3 хөрс хуулсан. Нийт 31,412.3

мян.м3 уулын цулын ажил гүйцэтгэхээс 30,633.0 мян.м3 уулын цулын ажил гүйцэтгэж, төлөвлөгөөг 97.5 хувьтай гүйцэтгэсэн байна.

Тайлант онд нийт 244,296.3 сая төгрөг орлого олж, 251,656.9 сая төгрөг зардал гарган 7,360.7 сая төгрөг алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 241,590.0 сая төгрөг орлого олж, 239,938.4 сая төгрөг зардал гарган татварын дараах байдлаар 1,651.6 сая төгрөгийн ашигтай ажиллаж, төлөвлөсөн алдагдлыг 9,012.3 сая төгрөгөөр бууруулан ажилласан байна.

2023 оны нэг тонн нүүрсний өртөг 47,783.0 төгрөг, нэг м3 уулын цулын өртөг 7,633.3 төгрөг байсан бол 2024 онд нэг тонн нүүрсний өртөг 48,458.4 төгрөг буюу төлөвлөснөөс 3,493.9 төгрөгөөр, 1м3 уулын цулын өртөг 7,842.1 төгрөг буюу төлөвлөснөөс 169.3 төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 36,566.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 33,643.3 сая төгрөг зарцуулсан байна. Хөрс хуулалт, нүүрс тээврийн 90 тн даацтай 3 самосвал, 1 дугуйт бульдозер, хүн тээврийн 2 автобус, ачаа суудлын 4 пикал худалдан авсан байна. Мөн 17 машин болон илчит тэргэнд их засварын ажил хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Багануур ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Багануур ХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Багануур ХК-ийн үйл ажиллагааг сайжруулах элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, нөөц өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах, худалдан авах ажиллагаатай холбоотой бичиг баримтуудын иж бүрдлийг хангаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор П.Энхцэлмэг, О.Цэндхүү, Б.Цогзолмаа, М.Цэнд-Аюуш, аудитор Э.Ундрах-Эрдэнэ, Т.Алтанчимэг, М.Мишээл нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Энхцэцэг, Гүйцэтгэх захирал Т.Одончимэг нар анхан шатны хяналтыг, Үндэсний аудитын газрын аудитор Э.Бат-Эрдэнэ, аудитын менежер С.Нацагдорж, Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2025 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 01/181 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тодотгосон төлөвлөгөөг, суурь үзүүлэлтийг нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшний тодотгосон төлөвлөгөөг суурь үзүүлэлтээр нийт зардлын 251,657.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,774.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор компанийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах зорилгоор үр ашигтай байх зарчмыг баримталж тайлангийн хугацаанд техник тоног төхөөрөмж, автомашинуудад хийх засвар үйлчилгээнээс 2,449.0 сая төгрөг, үйл ажиллагаанаас бичиг хэргийн зардал 3.2 сая төгрөг, удирдах албан тушаалтны шатахууны зардал 30.0 сая төгрөг, зар сурталчилгаа хэвлэл мэдээллийн зардал 11.3 сая төгрөг, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох зардал 382.8 сая төгрөг, дулааны зардал 91.9 сая төгрөг, сургалтын зардал 17.2 сая төгрөг, дотоод албан томилолтын зардал 5.3 сая төгрөг, цалингийн зардал 1,596.6 сая төгрөгийн хэмнэлтийг тус тус бий болгожээ. Багануур ХК нь төрийн хэмнэлтийн тухай хууль түүнтэй холбогдон гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлэлт дүгнэлт өгөхөөр 14 асуудлын зөвлөмжийг 93.0 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 5,248.1 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өмнөх аудитаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж байх албан шаардлага хэрэгжээгүй, тайлант онд 347 удаагийн орлого, 517 удаагийн зарлагын гүйлгээг хугацаа хоцроож, 32 удаагийн 1,402.3 сая төгрөгийн орлого, 29 удаагийн 1,198.1 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.10 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар хүргүүлсэн шийдвэрийг хэрэгжүүлээгүй ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1:

Өмнөх аудитаар өгсөн тендерийн нээлтийн тэмдэглэлийг бүрэн үйлдээгүй, худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгүүдэд үнэлгээний хорооны гишүүдийн гарын үсэг дутуу, ашиг сонирхлын зөрчилгүйн мэдэгдлийг зарим үнэлгээний хорооны гишүүд бөглөөгүй, хуулийн дагуу заавал үйлдэх баримт бичгүүдийг дутуу үйлдсэн, хурлын тэмдэглэлд гишүүдийн саналыг тодорхой тусгаагүй, буюу тендерийн баримт бичгийн бүрдэл хангалтгүй байна гэсэн зөвлөмж хэрэгжээгүй, тайлант онд үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, тендерийн баримт бичиг болон бусад баримт бичгийн бүрдэлтэй холбоотой 2,647.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.4 "Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана", 48.4.1 "санхүүжилтийн эх үүсвэр баталсан шийдвэр", 48.4.2 "нээлттэй тендер шалгаруулалтын аргаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгох болсон үндэслэл", 48.4.3 "захиалагчийн баталсан тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт", 48.4.4 "захиалагч, оролцогчтой харилцсан албан бичиг",

48.4.5 "оролцогчдын ирүүлсэн тендер", 48.4.6 "үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж", 48.4.7 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл", 48.4.8 "захиалагчийн шийдвэр", 48.4.9 "худалдан авах гэрээ", 48.4.10 "энэ хуулийн 13.4-т зааснаар баримтжуулсан гэрэл зураг, дүрс бичлэг", 48.4.11 "бусад баримт бичиг", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд давтан гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 3-р улирлын санхүүгийн тайланг хамруулж, санхүүгийн тайлангийн бүх дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр 46,521.5 сая төгрөгийн 23 асуудлыг залруулах, ажил сайжруулахаар Багануур ХК-ийн удирдлагад өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган ажлын хэсэг томилон ажиллаж 41,401.5 сая төгрөгийн 14 асуудал залруулсан 9 асуудлыг жилийн эцсийн тайланд алдаа зөрчлөөр тайлагнасан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 16,463.9 сая төгрөгийн 13 зөрчил илэрснээс давтан гаргахгүй ажиллах 10,808.2 сая төгрөгийн 7 албан шаардлага, хариуцлага тооцох 4,079.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, 1,576.2 сая төгрөгийн 4 зөвлөмж өгснөөс 3 албан шаардлага, 1 зөвлөмж хэрэгжээгүй хэрэгжилт 69.2 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитаар өгсөн | | Биелэлт | | |
|-----------------------------------|----------------------|---------------------|----------|---------------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 7 | 10,808,011.7 | 4 | 10,296,939.9 | 57.1 |
| Хариуцлага тооцох албан шаардлага | 2 | 4,079,701.0 | 2 | 4,079,701.0 | 100.0 |
| Зөвлөмж | 4 | 1,576,200.0 | 3 | 1,576,200.0 | 75.0 |
| Нийт дүн | 13 | 16,463,912.7 | 9 | 15,952,840.9 | 69.2 |

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмж хэрэгжээгүй дараах зөрчлүүд байна.Үүнд:

Өмнөх аудитаар тогтоосон 32.9 сая төгрөгийн төлбөрийн актыг компанийн хөрөнгөөс төлж барагдуулсан буюу төлбөрийн актыг холбогдох хууль дүрэм, журмын дагуу хэрэгжүүлээгүй, төрийн байгууллагад хохирол учруулж, зөрчлийг давтан гаргасан байна гэсэн албан шаардлага бүрэн хэрэгжээгүй 30.9 сая төгрөгийн зөрчил төлөгдөөгүй байгаад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Тендерийн нээлтийн тэмдэглэлийг бүрэн үйлдээгүй, худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгүүдэд үнэлгээний хорооны гишүүдийн гарын үсэг дутуу, ашиг

сонирхлын зөрчилгүйн мэдэгдлийг зарим үнэлгээний хорооны гишүүд бөглөөгүй, хуулийн дагуу заавал үйлдэх баримт бичгүүдийг дутуу үйлдсэн, хурлын тэмдэглэлд гишүүдийн саналыг тодорхой тусгаагүй, буюу тендерийн баримт бичгийн бүрдэл хангалтгүй байна гэсэн зөвлөмж хэрэгжээгүй, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, тендерийн баримт бичиг болон бусад баримт бичгийн бүрдэлтэй холбоотой 2,647.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Удаан хугацаагаар гадна талбайд хадгалагдаж байгаа хадгалалт хамгаалалт муугаас зэвэрсэн, будаг нь хуурсан, хуучирсан, ашиглагдахаа больсон хөрөнгүүдийг зарж борлуулах ажил зохион байгуулаагүй, чанарын шаардлага хангахгүй, техник хэрэгсэлд тохирохгүй болсон зэргээс шалтгаалж насжилт өндөртэй бараа материалын нөөц үүссэн гэсэн албан шаардлага хэрэгжээгүй, тайлант онд худалдан авч зарцуулаагүй 49 нэр төрлийн 587.7 сая төгрөгийн бараа хадгалагдаж байгаа зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 558 удаагийн орлого, 821 удаагийн зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 23 удаагийн 478.1 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээллээгүй байна гэсэн албан шаардлага хэрэгжээгүй тайлант онд 347 удаагийн орлого, 517 удаагийн зарлагын гүйлгээг хугацаа хоцроож, 32 удаагийн 1,402.2 сая төгрөгийн орлого, 29 удаагийн 1,198.1 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх, дээд шатны байгууллагын аудитаар анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- БНХК/20240101095 дугаартай "Нөхөн сэргээлт тендерийн багц №3 Шилмүүст модны суулгац"-д МОЁТ ХХК шалгарч 24/12-110 дугаартай гэрээ байгуулсан боловч гэрээний гүйцэтгэл хангалтгүй, 120 ш бортогтой мод ирснийг шаардлага хангахгүй буцаасан байна. 2025 оны 5 дугаар сард суулгацуудыг хүлээн авахаар хойшлуулан албан бичгээр тохиролцсон байна. Ногоон харш ХХК-иас тендерийн гэрээгээр 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр 25 төрлийн 960 ш бортогтой жимсний суулгац ирсэн боловч 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр газар хөлдсөн гэсэн шалтгаанаар суулгаагүй асуудлыг дараагийн аудитаар анхаарах;
- Эрдэнэс Монгол ХХК болон Багануур ХК-ийн хооронд 62,413.8 сая төгрөгийн урт хугацаат зээл болон зээлийн хүүгийн өр бүртгэлтэй байхад жил бүр борлуулалтын орлогын 2 хувиар менежментийн төлбөр төлөхөөр тооцоо үүсгэж 21,253.6 сая төгрөгийн өр төлбөр нэмэгдсэн байна Энэ нь компанийн санхүүгийн тайлан, төлбөрийн чадварын үзүүлэлт, компанийн үнэ цэнэд сөргөөр нөлөөлж байгааг дараагийн шатны аудитаар анхаарах;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийг шинэчлэн сайжруулсан эсэхийг дараагийн аудитаар анхаарах
- Татварын байгууллагад төлөх өр төлбөр 76,622.7 сая төгрөгийг барагдуулахгүй байгааг дараагийн шатны аудитаар анхаарах.
- Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2022 онд орлогч дарга нарыг цомхотгож, тэтгэмж олгож ажлаас чөлөөлсөн асуудлыг дараагийн аудитаар анхаарах
- Шинээр нэмэгдсэн орон тоо, эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлтийн үндэслэл, хэрэгжилт, үр дүнг дараагийн аудитаар анхаарах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,001.5 сая төгрөгийн 7 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн тайланд толгой компаниас охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын дүнг 93.5 сая төгрөгөөр дутуу тусгасан;
- Компьютер, тоног төхөөрөмж дансанд бүртгэх хөрөнгийг тавилга эд хогшил дансанд бүртгэсэн;
- Тайлант онд дахин үнэлсэн 2,628.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэхдээ эздийн өмчийн хэсгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгээгүй эздийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэсэн;
- НӨАТ-ын тайлангаарх борлуулалтын нийт орлого 15.1 сая төгрөгийг зөрүүтэй тайлагнасан;
- Нийгмийн даатгалын тайлангаар нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 1,138.2 сая төгрөг, санхүүгийн тайланд 1,180.2 сая төгрөгийн өглөгтэйгээр зөрүүтэй тайлагнасан;
- Бусад торгууль хөнгөлөлтийн зардал дансан дахь 16,846.0 сая төгрөгийн 7 гүйлгээтэй холбоотой нотлох баримтуудыг ирүүлээгүй ба эдгээр гүйлгээг орлого зарлагын нэгдсэн дансанд хаасан;
- Бараа материалын товчоо тайлангийн дүн бараа материалын журналын дүнгээс 376.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг тус тус залруулсан.

Аудитаар 845.1 сая төгрөгийн 11 зөрчил илэрснээс 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй байх 222.3 сая төгрөгийн 3 албан шаардлага, 618.6 сая төгрөгийн 2 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 3.6 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 845.1 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 3,774.8 сая төгрөгөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Ажиллагсдын хоол, унаа, нүүрсний хөнгөлөлтийг дундаж цалинд оруулж тооцоноос 10 хүнд 0.6 сая төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 тоот тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 1.5 "Ажилтанд олгож байгаа бүх төрлийн олговор (богиносгосон цагаар ажиллах үеийн, сул зогсолтын үеийн олговор гэх мэт), тэтгэмж (нярай хүүхэд үрчлэн авсан эцэг, эхэд олгох тэтгэмж гэх мэт), нөхөн төлбөр, хөнгөлөлт (унаа, хоолны үнийн хөнгөлөлт гэх мэт)-ийг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 0.6 сая төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Актын 33.0 сая төгрөгийн төлбөрийг компанийн хөрөнгөөс барагдуулсныг буруутай этгээдээр буцаан төлүүлж, төрд учирсан хохирлыг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 31.0 сая төгрөг төлөгдөөгүй үлдэгдэлтэй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх

хариуцлага 42.1.Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй ерөнхий нягтлан бодогчид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, төрд учирсан хохирлыг тухайн буруутай шийдвэр гаргасан этгээдээр нөхөн төлүүлэх хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

2. Удаан хугацаагаар гадна талбайд хадгалагдаж байгаа хадгалалт хамгаалалт муугаас зэвэрсэн, будаг нь хуурсан, хуучирсан, ашиглагдахаа больсон хөрөнгүүдийг зарж борлуулах ажил зохион байгуулаагүй, чанарын шаардлага хангахгүй, техник хэрэгсэлд тохирохгүй болсон зэргээс шалтгаалж насжилт өндөртэй бараа материалын нөөц үүссэн гэсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд худалдан авч зарцуулаагүй 49 нэр төрлийн 587.6 сая төгрөгийн бараа хадгалагдаж байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

3. Бараа материалын хяналтын тооллогоор 358 нэр төрлийн 7,976 ширхэг 7,139.6 сая төгрөгийн барааны үлдэгдэлд биет тест хэрэгжүүлэхэд 4.5 сая төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг эргэхийн редукторын араа удаан хадгалагдсан хуучин бараа байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Техникийн тодорхойлолтод заасан нөхцлийн дагуу хөрөнгө худалдан аваагүй зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 60,983.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа ба үүнээс 41,632.7 сая төгрөгийн 10,085 ширхэг хөрөнгийг актлах, 19,198. сая төгрөгийн 2,086 ширхэг хөрөнгийг дахин үнэлж бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг 2 удаа Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулсан боловч шийдвэрлүүлээгүй хойшлуулсан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь

эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ". Компанийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.1.8 "Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн зах зээлийн үнийг тогтоох, данснаас хасах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, өртгийг бодитой тогтоож бүртгэлд тусгах талаар холбогдох арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5. Тайлант онд 4 төрлийн барааг их хэмжээгээр худалдан авч, оны эцэст 151,640 ширхэг 217.8 сая төгрөгийн бараа үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэлгүй шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэн, нөөцлөж байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Санхүүгийн програмтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сангийн яамны нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн програм хангамжийн жагсаалтаас хасагдсан, хөгжүүлэлт хийгдэх боломжгүй Интерактив ХХК-ийн Diamond-5 програмыг 2009 оноос эхлэн ашиглаж байгаагаас санхүүгийн тайлангийн дансдын ангилал зөв тайлагнах боломжгүй, эксел файлаар санхүүгийн тайланг тайлагнаж, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хангах зохион байгуулалтыг хийгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 361 тоот тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжид мөрдөх Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" болон Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ыг хангаж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн програмыг холбогдох хууль стандартад нийцүүлэн шинэчлэн сайжруулах.

2. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Нэг цагийн дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо ажилтанд тодорхой хугацаанд олгосон цалин хөлсний нийлбэрийг тухайн хугацаанд ажилласан нийт цагийн тоонд хувааж тооцох журамтай байтал ажилласан цагийн тоонд илүү цагийг нэмж тооцон ажиллагсдын гарт олгогдох цагийн хөлсийг бууруулан олгож, ажиллагсдыг хохироож байна.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 2.1.3."Нэг цагийн дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо ажилтанд тодорхой хугацаанд олгосон цалин хөлсний нийлбэрийг тухайн хугацаанд ажилласан нийт цагийн тоонд хувааж тооцно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдын дундаж цалин хөлсийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэн зөв тооцоолж олгох.

Илрүүлэлт 2: Харилцагч банканд хүргүүлсэн ажиллагсдын гарт олгохоор тооцсон цалингаас хуримтлалын суутгалуудыг бүх ажиллагсдаас тогтмол суутгаж байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно: 119.1.1.ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг ажилтнаар нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан; 119.1.2.шүүхийн, эсхүл хөдөлмөрийн эрхийн маргаан шийдвэрлэх байгууллагын шийдвэр хүчин төгөлдөр болсон; 119.1.3.ажилтанд энэ хуулийн 123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан; 119.1.4.хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.. гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдын цалин, хөлсийг үнэн зөв тооцоолж олгох.

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Кабель утас нийлүүлэх 379.9 сая төгрөгийн гэрээний хугацааг 19 хоног хэтрүүлэн биелүүлсэнд, гэрээний тусгай нөхцөлд заасан хоног тутамд 0.05 хувийн алданги тооцно гэсэн заалтын дагуу 3.6 сая төгрөгийн алданги тооцоогүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 "захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах" эсвэл "гэрээний тусгай нөхцөлд заасан хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, гэрээний заалтын биелэлтэд хяналт тавьж ажиллах.

4. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Толгой компанид өгөх Менежментийн төлбөрт 21,253.6 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөр бүртгэлтэй байна. Уг менежментийн төлбөрийг борлуулалтын орлогын 2 хувиар тооцож байгаа нь охин компанийн санхүүгийн чадвар, ашигт ажиллагаатай уялдахгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 108 дугаар тогтоолын хавсралт Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.5.3-т "Энэ дүрмийн 3.5.2-т заасан гэрээний дагуу охин, хараат компани, харьяа хуулийн этгээд, компанид менежментийн төлбөр төлнө. Менежментийн төлбөрийн хувь хэмжээ нь борлуулалтын орлогын 2 (хоёр) хүртэл хувь байна." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компани их хэмжээний өр төлбөртэй байхад борлуулалтын орлогын 2 хувиар менежментийн төлбөр төлөхөөр тооцоо үүсгэж байгаа асуудлыг толгой компанид танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | | | |
|--|------------|-----------------|-----------------------------------|--------------|--------------------------|-----------------|------------|-----------------|-----------------|----------|-----------------|----------|----------|
| | Тоо | Дун | Тоо | Дун | Тоо | Дун | Залруулсан | | Залруулаагүй | | | | |
| | | | | | | | Тоо | Дун | Тоо | Дун | | | |
| Алдааны товч утга | | | | | | | | | | | | | |
| Санхүүгийн тайланд толгой компаниас охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын дүнг 93.5 сая төгрөгөөр дутуу тусгасан | 1 | 93.5 | 1 | 93.5 | - | - | - | 1 | 93.5 | - | - | - | - |
| Компьютер, тоног төхөөрөмж дансанд бүртгэх хөрөнгийг тавилга эд хошигш дансанд бүртгэсэн | 1 | - | - | - | 1 | - | - | 1 | - | - | - | - | - |
| Тайлант онд дахин үнэлсэн 2,628.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэхдээ эздийн өмчийн кэслийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгээгүй-эздийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэсэн | 1 | 2,628.9 | - | - | 1 | 2,628.9 | - | 1 | 2,628.9 | - | - | - | - |
| НӨАТ-ын тайлангаарх борлуулалтын нийт орлого 15.1 сая төгрөгийг зөрүүтэй тайлагнасан | 1 | 15.1 | 1 | 15.1 | - | - | - | 1 | 15.1 | - | - | - | - |
| Нийгмийн даатгалын тайлангаар нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 1,138.2 сая төгрөг, санхүүгийн тайланд 1,180.2 сая төгрөгийн өглөгтэйгээр зөрүүтэй тайлагнасан | 1 | 42.0 | 1 | 42.0 | - | - | - | 1 | 42.0 | - | - | - | - |
| Бусад торгууль хөнгөлөлтийн зардал дансан дахь 16,846.0 сая төгрөгийн 7 гүйлгээтэй холбоотой нотлох баримтуудыг ирүүлээгүй ба эдгээр гүйлгээг орлого зарлагын нэгдсэн дансанд хаасан | 1 | 16,846.0 | - | - | 1 | 16,846.0 | - | 1 | 16,846.0 | - | - | - | - |
| Бараа материалын товчоо тайлангийн дүн бараа материалын журналын дүнгээс 376.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг тус тус залруулсан | 1 | 376.0 | 1 | 376.0 | - | - | - | 1 | 376.0 | - | - | - | - |
| Дүн | 7 | 20,001.5 | 4 | 526.6 | 3 | 19,474.9 | 7 | 20,001.5 | 20,001.5 | 7 | 20,001.5 | - | - |

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Үүнээс | | | | | | | | | | /сая төгрөгөөр/ |
|---|-------------|-------|---------------|-----|-----------------|-------|---------|-----|--------------------------------------|-------|-----------------|
| | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | |
| | Тоо | Дун | Тоо | Дун | Тоо | Дун | Тоо | Дун | Тоо | Дун | |
| Ажиллагсдын хоол, унаа, нүүрсний хөнгөлөлтийг дундаж цалинд оруулж тооцоноос 10 хүнд 0.6 сая төгрөгийг илүү олгосон байна | 1 | 0.6 | 1 | 0.6 | - | - | - | - | - | - | - |
| Актын 33.0 сая төгрөгийн төлбөрийг компанийн хөрөнгөөс төлснийг буруутай этгээдээр буцаан төлүүлж, төрд учирсан хохирлыг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 31.0 сая төгрөг төлөгдөөгүй үлдэгдэлтэй байна | 1 | 30.9 | - | - | - | - | - | - | 1 | 30.9 | - |
| Удаан хугацаагаар гадна талбайд хадгалагдаж байгаа хадгалалт хамгаалалт муугаас завьрсан, будаг нь хуурсан, хуучирсан, ашиглагдахаа больсон хөрөнгүүдийг зарж борлуулах ажил зохион байгуулаагүй, чанарын шаардлага хангахгүй, техник хэрэгсэлд тохирохгүй болсон зэргээс шалтгаалж насжилт өндөртэй бараа материалын нөөц үүссэн гэсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд худалдан авч зарцуулаагүй 49 нэр төрлийн 587.6 сая төгрөгийн бараа хадгалагдаж байна | 1 | 587.7 | - | - | - | - | - | - | 1 | 587.7 | - |
| Бараа материалын хяналтын тооллогоор 358 нэр төрлийн 7,976 ширхэг 7,139.6 сая төгрөгийн барааны үлдэгдэлд биет тест хэрэгжүүлэхэд 4.5 сая төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг эргэхийн редукторын араа удаан хадгалагдсан хуучин бараа байна | 1 | 4.5 | - | - | 1 | 4.5 | - | - | - | - | - |
| Элэгдлээрээ анхны өртөө бүрэн нөхсөн 60,983.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа ба үүнээс 41,632.7 сая төгрөгийн 10,085 ширхэг хөрөнгийг актах, 19,198 сая төгрөгийн 2,086 ширхэг хөрөнгийг дахин үнэлж бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг 2 удаа Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулсан боловч шийдвэрлүүлээгүй хойшлуулсан байна | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - | - |
| Тайлант онд 4 төрлийн барааг их хэмжээгээр худалдан авч, оны эцэст 151,640 ширхэг 217.8 сая төгрөгийн бараа үлдэгдэлтэй байна | 1 | 217.8 | - | - | 1 | 217.8 | - | - | - | - | - |

Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын аудитын тайлан

| | | | | | | | | | | |
|---|-----------|--------------|----------|------------|----------|--------------|----------|------------|----------|--------------|
| Сангийн яамны нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн програм хангамжийн жагсаалтаас хасагдсан, хөгжүүлэлт хийгдэх боломжгүй Интерактив ХХК-ийн Diamond-5 програмыг 2009 оноос эхлэн ашиглаж байгаагаас санхүүгийн тайлангийн дансдын ангилал зөв тайлагнаж боломжгүйгээс экселээр файлаар санхүүгийн тайланг тайлагнаж, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хангах зохион байгуулалтыг хийгээгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| Нэг цагийн дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо ажилтанд тодорхой хугацаанд олгосон цалин хөлсний нийлбэрийг тухайн хугацаанд ажилласан нийт цагийн тоонд хувааж тооцох журамтай байтал ажилласан цагийн тоонд илүү цагийг нэмж тооцон ажиллагсдын гарт олгогдох цагийн хөлсийг бууруулан олгож, ажиллагсдыг хохироож байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| Харилцагч банканд хүргүүлсэн ажиллагсдын гарт олгохоор тооцсон цалингаас хуримтлалын суутгалуудыг бүх ажиллагсдаас тогтмол суутгаж байна | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| Кабель утас нийлүүлэх 379.9 сая төгрөгийн гэрээний хугацааг 19 хоног хэтрүүлэн биелүүлсэнд, гэрээний тусгай нөхцөлд заасан хоног тугамд 0.05 хувийн алданги тооцмо гэсэн заалтын дагуу 3.6 сая төгрөгийн алданги тооцоогүй байна. | 1 | 3.6 | - | - | - | - | 1 | 3.6 | - | - |
| Толгой компанид өгөх Менежментийн төлбөрт 21,253.6 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөр бүртгэлтэй байна. Уг менежментийн төлбөрийг борлуулалтын орлогын 2 хувиар тооцож байгаа нь охин компанийн санхүүгийн чадвар, ашигт ажиллагаатай уялдаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| Дүн | 11 | 845.1 | 1 | 0.6 | 3 | 222.3 | 5 | 3.6 | 2 | 618.6 |

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|--|-------------|----------------|-----------------|----------------|-----------------------------------|----------------|
| | | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой зөрчил | | | | | | |
| Өмнөх аудитаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж байх албан шаардлага хэрэгжээгүй, тайлант онд 347 удаагийн орлого, 517 удаагийн зарлагын гүйлгээг хугацаа хоцроож, 32 удаагийн 1,402.3 сая төгрөгийн орлого, 29 удаагийн 1,198.1 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна. | 1 | 2,600.3 | - | - | 1 | 2,600.3 |
| Дүн | 1 | 2,600.3 | - | - | 1 | 2,600.3 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Өмнөх аудитаар өгсөн тендерийн нээлтийн тэмдэглэлийг бүрэн үйлдээгүй, худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгүүдэд үнэлгээний хорооны гишүүдийн гарын үсэг дутуу, ашиг сонирхлын зөрчилгүйн мэдэгдлийг зарим үнэлгээний хорооны гишүүд бөглөөгүй, хуулийн дагуу заавал үйлдэх баримт бичгүүдийг дутуу үйлдсэн, хурлын тэмдэглэлд гишүүдийн саналыг тодорхой тусгаагүй, буюу тендерийн баримт бичгийн бүрдэл хангалтгүй байна гэсэн зөвлөмж хэрэгжээгүй, тайлант онд үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, тендерийн баримт бичиг болон бусад баримт бичгийн бүрдэлтэй холбоотой 2,647.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. | 1 | 2,647.7 | 1 | 2,647.7 | - | - |
| Дүн | 1 | 2,647.7 | 1 | 2,647.7 | - | - |
| Нийт дүн | 2 | 5,248.0 | 1 | 2,647.7 | 1 | 2,600.3 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 03 дугаар сарын 14 № 177/00150458
СМДГ-2025/001/НА-СТА-ТӨМГ

ӨМӨН-ХАЛТГАЛ 407

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажиллагсдын хоол, унаа, нүүрсний хөнгөлөлтийг дундаж цалинд оруулж тооцсоноос 10 хүнд 618,672.00 /Зургаан зуун арван найман мянга зургаан зуун далан хоёр/ төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 1.5 "Ажилтанд олгож байгаа бүх төрлийн олговор (богиносгосон цагаар ажиллах үеийн сул зогсолтын үеийн олговор гэх мэт), тэтгэмж (нярай хүүхэд үрчлэн авсан эцэг, эхэд олгох тэтгэмж гэх мэт), нөхөн төлбөр, хөнгөлөлт (унаа, хоолны үнийн хөнгөлөлт гэх мэт)-ийг ажиглалтын цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3 "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Илүү олгосон 618,672.00 / Зургаан зуун арван найман мянга зургаан зуун далан хоёр/ төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000001 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, ерөнхий нягтлан бодогч /Б.Наранбаатар/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
АУДИТЫН МЕНЕЖЕР,
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 640/АД/50458

Улаанбаатар хот

С.М.Т. - 0025/001/НА - СТА - ТӨЧГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Удаан хугацаагаар гадна талбайд хадгалагдаж байгаа хадгалалт хамгаалалт муугаас зэвэрсэн, будаг нь хуурсан, хуучирсан, ашиглагдахаа больсон хөрөнгүүдийг зарж борлуулах ажил зохион байгуулаагүй, чанарын шаардлага хангахгүй, техник хэрэгсэлд тохирохгүй болсон зэргээс шалтгаалж насжилт өндөртэй бараа материалын нөөц үүссэн байгаа зөрчлийг арилгахаар хүргүүлсэн өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд худалдан авч зарцуулаагүй 49 нэр төрлийн 587 688 022.00 /Таван зуун наян долоон сая зургаан зуун наян найман мянга хорин хоёр/ төгрөгийн бараа хадгалагдаж байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасныг тус тус зөрчсөн ба Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" -д заасан үндэслэл бүрдсэн болно.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албай тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Худалдаа, хангамж хариуцсан хэлтсийн дарга /Д.Хишигдэмбэрэл/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 641/20250438

Улаанбаатар хот

С.Н.АТ-0025/001/НА-СТА-ТОМГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

Тайлант онд 4 төрлийн барааг их хэмжээгээр худалдан авч, оны эцэст 151,640 ширхэг 217,744,369.05 /хоёр зуун арван долоон сая долоон зуун дөчин дөрвөн мянга гурван зуун жаран есөн/ төгрөгийн бараа үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4 "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэлгүй шаардлагагүйгээр их хэмжээний бараа, материал бэлтгэн, нөөцөлж байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, ерөнхий нягтлан бодогч /Б.Наранбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 642/00150458

Улаанбаатар хот

С.Н.Т. - 0025/001/НА-СТА-704Г

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 80,983,700,000.00 /Жаран тэрбум есөн зуун наян гурван сая долоон зуун мянган/ төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа ба үүнээс 41,632,700,000.00 /Дөчин нэгэн тэрбум зургаан зуун гучин хоёр сая долоон зуун мянган/ төгрөгийн 10,085 ширхэг хөрөнгийг актлах, 19,198,000,000.00 /Арван есөн тэрбум нэг зуун ерэн найман сая/ төгрөгийн 2,086 ширхэг хөрөнгийг дахин үнэлж бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг 2 удаа Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулсан боловч шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ". Компанийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.1.8 "Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн зах зээлийн үнийг тогтоох, данснаас хасах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, өртгийг бодитой тогтоож бүртгэлд тусгах талаар холбогдох арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, ерөнхий нягтлан бодогч /Б.Наранбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 643/20150458

Улаанбаатар хот

СНХТ-2025/001/НА-СТА-ТӨЛГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

Бараа материалын хяналтын тооллогоор 358 нэр төрлийн 7,976 ширхэг 7,139,600,000.00 /Долоон тэрбум нэг зуун гучин есөн сая зургаан зуун мянган/ төгрөгийн барааны үлдэгдэлд биет горим сорил хэрэгжүүлэхэд 4,475,563.00 /Дөрвөн сая дөрвөн зуун далан таван мянга таван зуун жаран гурван/ төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг эргэх редукторын араа удаан хадгалагдсан хуучин бараа байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4 "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Техникийн тодорхойлолтод заасан нөхцлийн дагуу хөрөнгө худалдан авахгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, ерөнхий нягтлан бодогч /Б.Наранбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 644/00150458

Улаанбаатар хот

СМДГ-2025/001/НА-СТА-ТӨУГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тендерийн нээлтийн тэмдэглэлийг бүрэн үйлдээгүй, худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгүүдэд үнэлгээний хорооны гишүүдийн гарын үсэг дутуу, ашиг сонирхлын зөрчилгүйн мэдэгдлийг зарим үнэлгээний хорооны гишүүд бөглөөгүй, хуулийн дагуу заавал үйлдэх баримт бичгүүдийг дутуу үйлдсэн, хурлын тэмдэглэлд гишүүдийн саналыг тодорхой тусгаагүй, буюу тендерийн баримт бичгийн бүрдэл хангалтгүй байгаа зөрчлийг арилгахаар өгсөн өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, тендерийн баримт бичиг болон бусад баримт бичгийн бүрдэлтэй холбоотой 2.647,738,220.00 /Хоёр тэрбум зургаан зуун дөчин долоон сая долоон зуун гучин найман мянган хоёр зуун хорин/ төгрөгийн зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.4 "Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана", 48.4.1 "санхүүжилтийн эх үүсвэр баталсан шийдвэр", 48.4.2 "нээлттэй тендер шалгаруулалтын аргаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгох болсон үндэслэл", 48.4.3 "захиалагчийн баталсан тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт", 48.4.4 "захиалагч, оролцогчтой харилцсан албан бичиг", 48.4.5 "оролцогчдын ирүүлсэн тендер", 48.4.6 "үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж", 48.4.7 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл", 48.4.8 "захиалагчийн шийдвэр", 48.4.9 "худалдан авах гэрээ", 48.4.10 "энэ хуулийн 13.4-т зааснаар баримтжуулсан гэрэл зураг, дүрс бичлэг", 48.4.11 "бусад баримт бичиг", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264231

Z:\Албан Шаардлага\2025\011\864Г-01.docx

1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд давтан гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, ерөнхий нягтлан бодогч /Б.Наранбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



ЦНАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 645/АД/50458

Улаанбаатар хот

СНАТ-2025/001/НА-СТП-784Г

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Актын 32,984,388.00 /Гучин хоёр сая есөн зуун наян дөрвөн мянга гурван зуун наян найман/ төгрөгийн төлбөрийг компанийн хөрөнгөөс төлснийг буруутай этгээдээр буцаан төлүүлж, төрд учирсан хохирлыг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 30,969,388.00 /Гучин сая есөн зуун жаран есөн мянга гурван зуун наян найман/ төгрөг төлөгдөөгүй үлдэгдэлтэй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй ерөнхий нягтлан бодогч /Б.Наранбаатар/-т хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, төрд учирсан хохирлыг тухайн буруутай шийдвэр гаргасан этгээдээр нөхөн төлүүлж, биелэлтийг 2025 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, Дотоод хяналт шалгалтын албаны дарга /Б.Хажидмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 654/АО/СОУС8

Улаанбаатар хот

Схем - 0025/001/НА-СТА-ТӨНГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж байх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд 347 удаагийн орлого, 517 удаагийн зарлагын гүйлгээг хугацаа хоцроож, 32 удаагийн 1,402,290,061.00 /Нэг тэрбум дөрвөн зуун хоёр сая хоёр зуун ерэн мянга жаран нэгэн/ төгрөгийн орлого, 29 удаагийн 1,198,061,478.00 /Нэг тэрбум нэг зуун ерэн найман сая жаран нэгэн мянга дөрвөн зуун далан найман/ төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.10 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэж тус тус заасантай нийцээгүй, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" заасан үндэслэл бүрдсэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй санхүү, эдийн засгийн бодлогын хэлтсийн дарга /Ж.Болд-Эрдэнэ/ д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Багануур ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/, Дотоод хяналт шалгалтын албаны дарга /Б.Хажидмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Т.ОДОНЧИМЭГ